ГОВЬСҮМБЭР АЙМАГ
# БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 01 өдөр          Дугаар 91/09          Баянтал сум

## Б.Бямбасүрэн-г ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулагын 79 дүгээр зүйлийн 79.1, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.2.4, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 166 дугаар тушаал "Ээлжийн амралтын олговор тооцох журам"-ын заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумын Эрүүл мэндийн төвийн даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч Б.Бямбасүрэн нь 2022 оны 08-р сарын 15-ны өдөр өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх өргөдөл гаргасан тул 2022 оны 09-р сарын 01-ний өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зохих журмын дагуу ажил хүлээлцэхийг комисст үүрэг болгосугай.

Комиссын дарга: Э.Эрхэмбаатар (Засаг даргын орлогч дарга)
Гишүүд: Ш.Алтанцэцэг (Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга)
Л.Отгонпүрэв (Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга
Б.Энхтөр (Эрүүл мэндийн төвийн Аж ахуйн нярав)
Нарийн бичгийн дарга: Э.Буянтогтох (Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн)

3. Б.Бямбасүрэнтэй холбогдох тооцоог хийж дуусгахыг Санхүү албаны нягтлан бодогч /Б.Амартүвшин/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА          Г.АНХБАЯР

D:/My Documents/2021 ajil/zahiramj.doc

421220225

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 01 өдөр  Дугаар Б/10  Баянтал сум

Э.Баасангаравыг ажилд түр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 107 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 05/10658 тоот албан бичгээр Хувийн ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Эрдэнэ овогтой Баасангаравыг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөр эхлэн Эрүүл мэндийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.
2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зохих журмын дагуу ажил хүлээлцэхийг комисст үүрэг болгосугай.

Комиссын дарга: Э.Эрхэмбаатар (Засаг даргын орлогч дарга)

Гишүүд: Ш.Алтанцэцэг (Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга)
Л.Отгонгүрэв (Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга)
Б.Энхтөр (Эрүүл мэндийн төвийн Аж ахуйн нярав)

Нарийн бичгийн дарга: Э.Буянтогтох (Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн)

3. Э.Баасангаравын цалинг ТҮЭМ-6 шатлалаар тогтоон үндсэн цалин (934899) есөн зуун гучин дөрвөн мянга найман зуун ерэн ес / төгрөгөөр, бусад холбогдох нэмэгдлийг хууль журмын дагуу бодож олгож байхыг Санхүү албаны нягтлан бодогч /Б.Амартүвшин/-д зөвшөөрсүгэй.

4. Э.Баасангарав нь томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ харьяа Эрх бүхий албан тушаалтанд гаргаж өгөх үүрэгтэй сануулсугай.

5. Э.Баасангарав ажилдаа хариуцлагатай хандаж, хууль тогтоомжийг чанд сахиж, төрийн албан хаагчийн ёс зүйг мөрдөж, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА  Г.АНХБАЯР

D;/My Documents/2021 ajil/zahiramj.doc

42122 0223